

**“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН
БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “буюу АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалж санхүүгийн зах зээлд тогтворгүй нөхцөл байдал үүсэхээс өмнө” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

2.Тогтоолын төслийн хавсралтын 2.7 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр” гэж, “2024 онд” гэснийг “2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр” гэж, 3.1 дэх хэсгийн “02 дугаар сард” гэснийг “2 дугаар сарын 18-ны өдөр” гэж, 3.3 дахь хэсгийн “06 дугаар сард” гэснийг “06 дугаар сарын 16-ны өдөр” гэж, 3.5 дахь хэсгийн “09 дүгээр сард” гэснийг “09 дүгээр сарын 02-ны өдөр” гэж, 3.6 дахь хэсгийн “2021 онд” гэснийг “2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.7 дахь хэсгийн “05 дугаар сард” гэснийг “05 дугаар сарын 15-ны өдөр” гэж, 3.9 дэх хэсгийн “10 дугаар сард” гэснийг “10 дугаар сарын 04-ний өдөр” гэж, 3.11 дэх хэсгийн “2031 онд” гэснийг “2031 оны 10 дугаар сарын 28-нд” гэж, 3.12 дахь хэсгийн “08 дугаар сард” гэснийг “08 дугаар сарын 29-ний өдөр” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

3.Тогтоолын төслийн хавсралтын 4.8 дахь хэсгийн “эхлүүлэх” гэснийг “тогтмол явуулах” гэж, “тогтмол арилжаалах төлөвлөгөөтэй байна.” гэснийг “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

4.Тогтоолын төслийн хавсралтын Стратеги 4-ийн “Улсын төсөв ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед” гэснийг “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй үед” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

Найруулгын санал:

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.5 дахь хэсгийн “түүхэн” гэсний өмнө “Засгийн газраас өмнө гаргаж байсан бондуудаас” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан” гэсний өмнө “баталгаа” гэж, 6.1 дэх хэсгийн “харьцааны төсөөллийг” гэсний өмнө “ДНБ-нд харьцуулсан” гэж, 6.2 дахь хэсгийн “хэмжээг 2026 онд” гэсний өмнө “ДНБ-нд эзлэх” гэж, “Дүгнэлт” хэсгийн “60.5 хувьтай” гэсний өмнө “2022 онд” гэж, “41.8 хувь” гэсний өмнө “2024 онд” гэж, “буурсан,” гэсний дараа “эдгээр онуудад” гэж тус тус нэмэх;

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.1 дэх хэсгийн “оршино” гэснийг “чиглэнэ” гэж, “Сангийн яам нь стратегийн баримт бичгийг” гэснийг “Санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг /цаашид “Стратегийн баримт бичиг” гэх/-ийг гэж, 2.1 дэх хэсгийн “Цар тахлын” гэснийг “Ковид-19 цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын” гэж, “2021 оноос 2024 оны хооронд нийт” гэснийг “2024 оны жилийн эцсийн байдлаар 2021 оны түвшнээс” гэж, “эзлэх хэмжээгээрээ” гэснийг “харьцуулсан харьцаа” гэж, 2.2 дахь хэсгийн “нэгжүүд” гэснийг “нэгж, байгууллагууд” гэж, 3.2 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэснийг “нэмэгдүүлэх” гэж, 3.5 дахь хэсгийн “зээлийн эх үүсвэрийг” гэснийг “зээлийг” гэж, 3.9 дэх хэсгийн “буцаан төлж” гэснийг “бүрэн төлж” гэж, Хүснэгт 6-ын “өрийн зардал” гэснийг “өрийн багцын зардал” гэж, 5.4 дэх хэсгийн “буурах төсөөлөл” гэснийг “бууралт” гэж, Стратеги 4-ийн “бүх хэсгийн хүрээнд” гэснийг “нийт хэмжээнд” гэж, 5.8 дахь хэсгийн “үнэт цаасны гаргалтыг” гэснийг “үнэт цаасны арилжааг” гэж, 6.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн харьцаа” гэснийг “уг харьцаа” гэж, “өрийн харьцааг” гэснийг “уг харьцааг” гэж, 6.2 дахь хэсгийн “хүрээний мэдэгдэлд” гэснийг “төсөөлөлд” гэж, “туссан дүнтэй” гэснийг “туссан хязгаарт” гэж тус тус өөрчлөх;

3.Тогтоолын төслийн 2.2 дахь хэсгийн “Голомт банкнаас” гэсний дараах “олон улсын зах зээлд” гэснийг, мөн хэсгийн “төрийн байгууллагуудын хувьд” гэснийг болон “гаргасан, мөн тус хугацаанд” гэснийг, 2.4 дэх хэсгийн “тогтмол” гэснийг, 3.1 дэх хэсгийн “хуульчлагдаж” гэснийг, 5.8 дахь хэсгийн “түлхүү” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

---oOo---